



ᠮᠤᠩᠭᠡᠯᠤᠯᠤᠰ
ᠤᠨᠳᠦᠰᠦᠨᠢ
ᠰᠤᠲᠤᠰᠢᠳᠢᠬᠤ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХОД ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

ҮСХ-ны ҮТШСГ-ын ахлах статистикч М.Оюунжаргал



I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

I.1. Хууль, эрх зүйн орчин

МУ-ын “Статистикийн тухай” хууль

- Анх батлагдсан – 1994 оны 03-р сарын 17
- Шинэчлэн найруулж, баталсан – 1997 оны 06-р сарын 05 (тус хууль 6 бүлэг, 23 зүйлтэй)

Нэмэлт өөрчлөлт- 9 удаа хийгдсэн.


- 1999 он: [АЭС-ийн мэдээллийн үзүүлэлт](#)
- 2003 он: [Ерөнхий менежерийн бүрэн эрх болон статистикийн байгууллагын тогтолцоонд](#)
- 2004 он: [Хуулийн 2-7, 11, 12, 18, 19, 22, 23-р зүйлүүдэд](#)
- 2008 он: [ХАОСТ-ын тухай хууль](#)
- 2011 он: [ХАА-н тооллого, ӨНЭЗС-г явуулах тухай](#)
- 2012 он: [Хуулийн 1-3 зүйлд нэршлийг өөрчилсөн.](#)
- 2013 он: [Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг явуулах тухай](#)
- 2015 он: [ХЗЯ-ны харьяа агентлаг болсноос оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд](#)
- [2016 он: ҮСХ болсноос оруулсан өөрчлөлтүүд](#)



МОНГОЛЫН
УЛСЫН
СТАТИСТИКИЙН
ХАНАГАА

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

I.2. Үндэсний статистикийн систем





II. ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭН НАЙРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

Олон улсын цогц үнэлгээ (2013-2014)

- СХ-ийг шинэчлэн найруулах (НҮБ-ын АЁС-ийн 10 зарчим зэрэг олон улсын зарчмуудтай бүрэн нийцүүлэн)
- ҮСС, Статистикийн байгууллагын бүтэц, тогтолцоог зааглах
- Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн зааг ялгааг тодорхой болгох
- Статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн цар хүрээ, бүтэц, түүнийг батлах журмын талаар тусгах
- СХ-нд мэдээлэл цуглуулах бүрэн эрхийг тодорхой тусгах
- Чанар, нууцлалыг хангах зарчмыг тодорхойлж, нарийвчлан тусгах

Нийцлийн мониторинг (2016)

- Давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хүрээнд нийт **12** хууль, **13** дүрэм, журмыг харьцуулан судалсан.
- Тайлангийн дүгнэлтээс: Статистикийн тухай хууль, дүрэм, журамд хамаарах нийт 33 давхардал, зөрчил, хийдлийг тогтоосон (давхардал 7, зөрчил 10, хийдэл 16).



II. ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭН НАЙРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

Статистикийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг зохицуулах

- “Статистикийн тухай” хуулинд тусгасан “Мэдээлэгчийн эрх, үүрэг”-т нэмэлт өөрчлөлт оруулж, тодорхой болгох
- “Цуглуулсан” болон “Тархаах” мэдээллийн нууцлалыг хэрхэн хангасан байх, ямар түвшний мэдээллийг нийтэд тархаах, хэнээс зөвшөөрөл авах зэрэг талаар тодорхой тусгах
- Мэдээллийг өгөхөөс татгалздаг, хугацаа хожимдуулдаг, буруу гаргадаг, шаардуулдаг иргэн, ААНБ-д тооцох хариуцлага, шаталсан, торгууль шийтгэлийг зааглах, шинэчлэх зэрэг

Шинээр үүсч буй хэрэгцээ шаардлага, хөгжлийн шинэ чиг хандлага

- Дэлхийн ТХЗ-2030 хөтөлбөрийг дэмжихэд чиглэсэн АЁС-ийн шинэчлэлийн хөтөлбөртэй уялдуулах
- Дэлхийн болон үндэсний ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг гаргах
- 1999 оноос хойш тусгагдсан 9 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг шинэчлэн найруулах



МОНГОЛЫН УНДСНИЙ СТАТИСТИК



III. ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭН НАЙРУУЛАХ ШААРДЛАГА



МОНГОЛЫН
УЛСЫН
СТАТИСТИКИЙН
ТӨР ИЙН
БАЙГУУЛЛАГУУД

III.1. Нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагын дагуу статистикийн мэдээллийн эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдэж, хэрэглээ өсөж байгаатай уялдуулан “Статистикийн тухай” хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Тухайлбал:

- Иргэд, ААНБ-аас ижил агуулгатай, нэг төрлийн мэдээ тайланг төрийн байгууллагууд авч ачаалал учруулж байна.
- Статистикийн мэдээллийг боловсруулж, нэгтгэн тооцож албан ёсоор зарлаагүй байхад эсхүл зарласнаас хойш төрийн байгууллагууд өөрсдийн мэдээллийг дур мэдэн өөрчилж, олон нийтийг төөрөгдүүлж байна.
- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудад статистикийн мэдээ тайланг гаргах талаар үүрэгжүүлсэн заалт тусгагдаагүй нь эрх зүйн зохицуулалтын хийдлийг үүсгэж байна.
- Албан ёсны статистикийн үзүүлэлтийг хэт дэлгэрэнгүй, захиргааны статистикийн мэдээллийг товч хуульчилсан нь түүнийг олон улсын жишиг, өөрийн орны онцлогтой уялдуулан өөрчлөхөд хүндрэл учруулж байна.
- Статистикийн зорилгоор цуглуулсан тоо мэдээллийг хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нотолгоо болгон баримтжуулж өгөхийг шаардах, хэрэглэгчдээс хуульд заасан АЭС-ийн мэдээллээс гадуурх, мөрдөж байгаа аргачлал, ангилал, стандартыг зөрчсөн мэдээлэл гаргуулахыг шаардах зэрэг хууль бус үйлдлийг зохицуулах шаардлага тулгарч байна.



IV. ХУУЛИНД ТУСГАХ ӨӨРЧЛӨЛТҮҮД

IV.1. “Статистикийн тухай” хуулинд дараах 5 чиглэлээр өөрчлөлт хийхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Хуулийн нэр томъёог шинэчлэн найруулах, шинээр тусгах өөрчлөлт

2. Үндэсний статистикийн систем, статистикийн байгууллагын тогтолцоо, ҮСХ-ноос бусадтай харилцах чиглэлээр хийх нэмэлт өөрчлөлт

3. АЁС-ийн шинэчлэлийн хөтөлбөр, ТХЗ-ийг хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлтийг тооцон гаргахтай холбогдох нэмэлт өөрчлөлт

4. Статистикийн байгууллагаас үйл ажиллагаагаа явуулахад тулгамдсан асуудлыг зохицуулах нэмэлт өөрчлөлт

5. Захиргааны статистикийн мэдээллийг ашиглахтай холбогдох нэмэлт өөрчлөлт



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬ



МОНГОЛЫН
УЛСЫН
СТАТИСТИК
ТӨВИЙН
ТӨР ИЙН
БАЙГУУЛЛАГА

IV. ХУУЛИНД ТУСГАХ ӨӨРЧЛӨЛТҮҮД

IV.2. Төрийн байгууллагуудтай харилцахтай холбогдон хийгдэх өөрчлөлт:

- Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн зааг ялгаа, хариуцах байгууллага, гаргах мэдээ, тайлангийн үзүүлэлтийг тодорхой болгох;
- Төрийн байгууллагуудын захиргааны статистикийн мэдээлэл, анхдагч мэдээллийн санг статистикийн үйл ажиллагаанд ашиглах, уялдуулах;
- Статистикийн аргачлал, ангилал, стандартыг бүрэн нэвтрүүлж, ашиглах;
- Нэг төрлийн мэдээллийн талаар нэг тоо мэдээлэлтэй байх;
- Төрийн байгууллагуудын статистикийн үйл ажиллагаатай холбогдон хүлээх үүрэг, эрх, хариуцлагыг тодорхой болгох үүднээс ҮСХ, яам, агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагатай харилцах талаар шинэ зүйл, заалт нэмэх;
- Захиргааны статистикийн мэдээллийг хянаж баталгаажуулах;
- Чанарын шаардлага хангасан уламжлалт бус тоо мэдээлэл (их өгөгдөл г.м)-ийг ашиглах;
- Статистикийн асуудал хариуцсан бие даасан нэгжтэй байх гэсэн заалтыг бодит ажил хэрэг болгох зэрэг болно.




V. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА



МОНГОЛЫН УНДСНИЙ СТАТИСТИК

V.1. “Албан ёсны статистикийн тухай ерөнхий хууль”

- 2016 онд НҮБ-ын Европын эдийн засгийн комиссоос “Албан ёсны статистикийн тухай ерөнхий хууль”-ийг баталсан (14 зүйл, 38 заалттай).
- Тус загвар хууль нь:
 - НҮБ-ын Албан ёсны статистикийн үндсэн зарчим, Европын статистикийн үйл ажиллагааны хуультай бүрэн нийцсэн;
 - Статистикийн талаарх үндэсний хууль, эрх зүйн орчинг сайжруулахад загвар жишиг болох:
 - # Мэргэжлийн бие даасан байдал, ҮСС-ийн ажлын уялдаа, тоо мэдээлэл цуглуулах, хянаж шалгах
 - # ҮСС-ийг шинэчлэгдэх нөхцлийг бүрдүүлэх
 - Статистикт итгэх олон нийтийн итгэл, албан ёсны статистикийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн баримт бичиг юм.





V. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА



ᠮᠣᠩᠭᠡᠯᠤᠯᠤᠰᠤᠨ
ᠤᠨᠳᠦᠰᠦᠨᠢ
ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠢᠶᠢᠨ

V.1. Тус хуулиас СХ-ийг шинэчлэн найруулахад дараах зүйл заалтыг авч ашиглавал зохистой гэж үзэж байна.

Албан ёсны статистикийн ерөнхий хууль

4.1 (с) Захиргааны тоон мэдээлэл гэж албан ёсны статистикийн мэдээлэл эрхлэн гаргадаг байгууллагаас бусад үндэсний болон орон нутгийн эрх бүхий байгууллагуудын нэрийн өмнөөс эсхүл тухайн байгууллагуудаас цуглуулсан тоон мэдээллийг ойлгоно.

11.1 Статистикийн хөтөлбөр, түүний дотор урт хугацааны хөтөлбөр болон жилийн үйл ажиллагааны хөтөлбөр нь үндэсний статистикийн системийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, стратеги болон үйл ажиллагааг үр дүнтэй удирдан хэрэгжүүлэх гол хэрэгсэл юм.

3.1 (а) Мэргэжлийн бие даасан байдал гэж албан ёсны статистикийг эрхлэн гаргадаг байгууллагууд улс төрийн эсхүл гадны аливаа дарамт шахалт, нөлөөнөөс ангид, бие даасан байдлаар статистикийн мэдээллийг боловсруулах, эрхлэн гаргах, тархаах, түүний дотор тоон мэдээллийн эх үүсвэр, ойлголт, тодорхойлолт, аргачлал, ангиллыг сонгох, тархаах мэдээний агуулга, хугацааны шийдвэр гаргахыг ойлгоно.

17.1 Үндэсний болон орон нутгийн эрх бүхий байгууллагууд албан ёсны статистикийн мэдээллийг эрхлэн гаргахад шаардлагатай дэлгэрэнгүй тоон мэдээлэл болон тоон мэдээллийн чанарыг үнэлэх боломжийг бүрдүүлдэг мета мэдээллийг албан ёсны статистикийн мэдээллийг эрхлэн гаргадаг байгууллагуудад үнэ төлбөргүй өгөх үүрэгтэй.



V. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА



МОНГОЛ УЛСЫН УНДСНИЙ СТАТИСТИК

Албан ёсны статистикийн ерөнхий хууль

3.1 (f) Статистикийн нууцлал, статистикийн зорилгоор зөвхөн ашиглах гэж албан ёсны статистикийг эрхлэн гаргадаг байгууллагууд олж авсан эсхүл цуглуулсан хувь хүн эсвэл хуулийн этгээдийн талаарх тоон мэдээллийг хатуу чанд нууцлаж, статистикийн зорилгоор зөвхөн ашиглахыг ойлгоно.

27.1 Албан ёсны статистикийн мэдээллийг эрхлэн гаргадаг байгууллагууд хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн байх, үнэн бодитой байх, шуурхай, цаг хугацаандаа байх, ил тод, ойлголжтой байх, нийцтэй байх, харьцуулах боломжтой байх гэсэн шалгуурын дагуу албан ёсны статистикийн мэдээллийн чанарыг тогтмол үнэлж, сайжруулж байх үүрэгтэй.

27.2 Чанарыг баталгаажуулахдаа албан ёсны статистикийн ойлголт, тодорхойлолт, нэгж, ангиллын нийтлэг стандарт, нэгдсэн аргалалын дагуу албан ёсны статистикийн мэдээллийг боловсруулан тооцож, тархаана.

27.3 АЁС-ийн чанарыг сайжруулах тулд АЁС-ийн мэдээллийг эрхлэн гаргадаг байгууллагууд статистикийн зорилгоор тоон мэдээллийг хянаж шалгах, өөр төрлийн эх үүсвэрийн тоон мэдээллийг нэгтгэх, хувь хүний тоон мэдээллийг холбох, уялдуулах, мэдээллийн зөрүүг арилгах үүднээс статистикийн тооцоолол хийх эрхтэй.



V. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА



МОНГОЛЫН УНДСНИМ СТАТИСТИК

V.2. Статистик өндөр хөгжсөн бусад орны туршлага

- Молдов Улс НҮБ-ын ЕЭЗК-оос 2016 онд гаргасан “Албан ёсны статистикийн ерөнхий хууль”-ийн бүтэц, агуулгыг баримтлан 2017 оны 05-р сард Статистикийн хуулиа шинэчлэн найруулж баталсан.
- Статистикийн зорилгоор захиргааны тоо мэдээллийг авч ашиглах эрхийн талаар хуулиндаа тодорхой заасан байдаг (Канад, Финланд, Норвег). Захиргааны мэдээллийг ашиглах шаардлага нь мэдээлэгч болон ААНБ, иргэнд ирэх ачаалал дарамтыг багасгахад чиглэгддэг.
 - # Финландад нийт мэдээллийн 97 хувь нь захиргааны мэдээлэл байдаг.
 - # Эстонид нийт мэдээллийн 70% нь захиргааны мэдээлэл байна.



VII. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



МОНГОЛЫН УНДСНИМ СТАТИСТИК

1. “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн дагуу “Статистикийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэх.
2. Тодорхой хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах.
Яам, агентлаг, төрийн бусад байгууллага, тухайлбал, Яам, агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Гаалийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүгийн хууль, Иргэний хууль, Монгол банкны тухай хууль зэрэгт нэмэлт өөрчлөлт оруулах. Үүнд:
 - Статистикийн асуудал хариуцсан нэгжтэй байж, эдгээр нэгжийг удирдлага, санхүүжилтээр хангаж, мэргэжлийн хувьд хараат бус байх нөхцлийг хангах
 - Мэдээллийн сангуудыг холбох, уялдуулах, сайжруулахад хамтран ажиллах зорилгоор тодорхой заалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах гэх мэт.
3. Төрийн холбогдох байгууллагуудаас санал авах.
4. СХ-ийн шинэчилсэн найруулгын төслөө ХЗДХЯ-нд танилцуулж, УИХ-д өргөн барих.



Улсын Статистик 9

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА